

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын тухай хуульд доор дурдсан агуулгатай 28² дугаар зүйл нэмсүгэй:

“28² дугаар зүйл.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

28².1.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

28².1.1.боловсролын болон холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

28².1.2.аймаг, нийслэлийн боловсролын газар болон боловсролын сургалтын байгууллагыг мэргэжил, арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

28².1.3.гамшгийн улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоох, хэлбэр өөрчлөх тохиолдолд сургалтын тасралтгүй байдлыг хангах хариу арга хэмжээ авах нэгдсэн зохицуулалт хийх;

28².1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.”

2 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4.9 дэх заалтын “санал” гэсний өмнө “хэрэгжүүлэх арга хэмжээ, төслийг эрэмбэлэх, шийдвэрлүүлэх” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг:

“27.1.Боловсролын удирдлагын тогтолцоо нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газар, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн болон боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагаас бүрдэнэ.”

2/40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг:

“40.1.Төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг суурь зардал болон дундаж нормативт үндэслэсэн хувьсах зардал, сургалтын байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үнэлгээний үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлаар санхүүжүүлж болно.”

3/43 дугаар зүйлийн 43.2.10 дахь заалт:

“43.2.10.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид Засгийн газраас тогтоосон хэмжээ, нөхцөлийн дагуу тэтгэлэг олгоно.”

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Эцэслэн батлах төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалтын “5” гэснийг “10” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 53 дугаар тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “2022-2023” гэснийг “2023-2024” гэж өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

**Авлигатай тэмцэх газрын албан
хаагчийн албан тушаалын цалингийн
хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 67 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИЙН
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Авлигатай тэмцэх газрын дарга	3 337 152
2	Авлигатай тэмцэх газрын дэд дарга	3 108 560
3	Хэлтсийн дарга	2 980 180
4	Албаны дарга	2 823 184
5	Ахлах ажилтан	2 687 202
6	Ажилтан	2 533 104
7	Туслах ажилтан	1 446 900